

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Санжаажав	Дугаар	L231
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Могод сумын төвд
Төрсөн газар	Могод сум	Төрсөн он	1922
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Таширын хийд	Сүм хийдийн дугаар	БУМГ 057
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-рсарын 13	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат



Булган аймгийн Могод сумын Таширын хийд

Д.Мөнхбат: За тэгэхээр та одоо Таширын хүрээнд сууж байсан хуврагуудаас цөөхөн үлдсэн хүмүүсийн нэгээ гэж сум орон нутгийн хүмүүсээс мэдээллийг авсан юмаа. Тэгэхээр би танаас дараах хэдэн зүйлийг асуух гэсэн юм. Та хэдэн настайдаа энэ Таширын хүрээнд шавилан суув? Тэгээд хэдэн жил болоод сум хийд хаагдах тэр үед эргээд хар болсон бэ?

Санжаажав: За би одоо багадаа 8 настай сахил авсан юм билээ. Тэгээд удаагүй шүү дээ ер нь 16, 15 орчим лам нэр хүртээд ирэхээр тэгэхээр хурал дацан чинь бүүгаад ирсэн тэгээд хөдөө гарсан.

Д. Мөнхбат: Тэгэхээр 7, 8 жил суусан гэж ойлгож болохнээ. Тэгээд таныг ингэж сууж байхад Таширын хүрээ хичнээн ламтай ямар ямар дуган дацантай ийм хурал номын газар байсан бэ ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Санжаажав: Цогчин дуган гээд гол дуган байлаа. Тэгээд цанидын дуган байсан , жүдийн дуган , мамбын дуган гээд 4 дугантай газар байсан.

Д.Мөнхбат: Цогчин , цанидын дуган, жүд, мамба гээд 4 дуган лам хуврагын тоо хэд байсан юм бол.

Санжаажав: За ингээд 120 иод байсан л гэж ярьдаг байсан.

Д. Мөнхбат: 120иод. Таширын хүрээний гол шүтээн сахиус гэж юу байсан юм болоо?

Санжаажав: Дамдинчойжин сахиус байсан.

Д. Мөнхбат: Дамдинчойжин сахиустай байсан тэхээр Таширын хүрээний хурал номын дэг жаяг бусад хүрээ хийдүүдээс ялгагдах өвөрмөц онцлог нь ямар байсан юм болоо? Тэр талаар одоо таньд сэтгэлд үлдсэн юм байнауу?

Санжаажав: Ер нь л одоо дөхүү байсан юм болуу гэж би бодсон. Нэг Авзагын хүрээнд майдарт очлоо цамд очсон юм Тэгсэн чинь намайг цам дага гээд би чинь бага байсан байсан шүү дээ тэгэхэд чинь ая дэг нь адилхан байна лээ тэрүүгээр нь л би адилхан юм байна гэж бодсон

Д. Мөнхбат : Тэгээд энэ Таширын хүрээ нь хойшоогоо Вангийн хүрээ Түшээтхан аймгийн хамгийн том хүрээ хийдийн нэг Вангийн хүрээ байна , зүүн тийшээгээ Авзагын хүрээ , Эрдэнэхамбын хийд гээд томоохон хийд зэрэг газруудтай их ойр байжээ одоо газарзүйн байрлалын хувьд гэдэг юмуу? Тэгэхээр энэ бусад тухайн үеийнхээ хүрээ хийдүүдтэй хэр холбоо бага юм болохоор ийш тийшээ тэр олон хүрээ хийд рүү явж байгаагүйдээ. Ганцхан л энэ Таширынхаа хүрээн дээр л сууж байгаад л харласан хэрэг. Тэгэхээр яахав энэ чинь аграмбын дамжаа , гавжийн дамжаа , домын дамжаа барьдаг ийм гурван номтой байсан Цам майдар гардаг.

Д.Мөнхбат: Цам майдар гардаг гэнээ?

Санжаажав: Тиймээ энэ чинь одоо майдар эргэдэг байсан юм. .

Д. Мөнхбат: Майдар зун хавар намар гээд хэдүй үед нь эргэдэг байв ?

Санжаажав : Аа тийм зүны цагт л майдар эргэдэг байсан даа.

Д. Мөнхбат : Та цамд гарч байсануу?

Санжаажав: Өө гарч байсан. / инээв/

Д. Мөнхбат: Тэгэхээр энэ Таширын хүрээ жас сангийн хувьд ямархуу байсан юм бэ ?

Санжаажав: Өө жастай байсаан., өөрийнхөө мандал шиваа хийнэ хөдөөний ардууд хурал хуруулна гол хурлуудыг өвлийн хурлууд гэж 15 , 29-ээс шинийн 15 хүртэл хурдаг байсаан өвлийн хурлуудыг нэг нэртэй юу гэдэг ч билээ дээ ганданд ч бас хурдаг шүүдээ.

Д. Мөнхбат: Тэгэхээр энэ монголын буддын шашны хүрээ хийдүүд хөдөө хот том жижиг гэлтгүй өөрийн хүрээ хийдээс төрч гарсан эрдэмтэй чадалтай шашны ухаанд мэргэшсэн ийм томоохон лам нар их байжээ. За хүрээ хийд болгонд л лам нарын нэр дурсагдаж түүхэнд үлдсэн байх юм. Тэгэхээр Таширын хүрээний хувьд аймагтаа Түшээт хандаа эрдэм чадлаараа гайхагдсан томоохон лам нар байсан бэ?

Санжаажав: За энэ чинь одоо нэг их тийм том лам нар ч байгаагүй юмдаа. Зүгээр яахав би өөрөө харж байгаагүй ч увидастай ч гэх юмуу аграмба багш гэж хийдэд нэг хүн байсан юм би анхлан лам

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болохдоо сахил авч хүртсэн багш юм байгаа юм. Тэрийг одоо нэг нутгийн томоотой Дамдиндорж гэж хүн ярьж байна хууч хөөрч байлаа. Тэрний эцэг нь урьд нэг удаа өвдөөд миний хүү нэг лам аваад ир гавьжийг аваад ир гэхэд морь хөтлөөд орсон чинь гэртээ байж байсан за таныг залах гэж ирлээ манай аав таныг авч ир гэсэн бие нь муу хэвтэж байгаа – за за гэв таньд номхон морь аваад ирсэн - үгүй ээ би морь унахгүй чи яв би мэдье гэж тэгээд нөгөөдөх чинь тамхи татаад / 17, 18 тай л байсан байгаа юм Дамдиндорж одооч нас сүүдэртсэн л дээ / зүгээр хөдөөний хүн байсан юм. Тэгээд тэр Таширын хуралтай хөтөл дээрээс Баянгол уруудаад давдаг газар байсан юм тэгээд л нөгөө замаа хараад гөлийгөөд суусан ирдэггүй гэнэ тэгээд нилээн уджээ тэгсэн үүр цайх болж тэгээд жаал даараад тамхи татаж нөгөө лам чинь яачваа энүүгээр л явна даа гээд хүлээгээд байсан байдаггүй гэнэ тэгээд хариад иртэл нөгөө лам чинь аль эрт ирсэн хийдэг юмнуудаа хийчихсэн юу гүрэм дом л хийдэг байсан байгаа юм чи хариад шар тос чихэр бэлдээд байж бай гэсэн гэж байгаа тэгсэн чинь харин түрүүлээд оччихсон байх юм та миний хаагуур ирэв гэтэл чи сая л ирж байна уу гэв. Сая л ирлээ гэхээс яахав та миний хаагуур гарчихав би яг л зам дээр байсан юм сан гэж гэнэ. Чиний хажуугаар л гарсан ш дээ чи яагаад харсангүй вэ гэж хэлсэн гэсэн.Тэгэхээр тийм л учиртай хүн байсан байгаа юм

Д. Мөнхбат: Тэгэхээр энэ Таширын хүрээн дээр монголын сүм хийдийн түүхийг аваад үзэхээр энэ 1937, 38 оны цөвүүн цаг үед лам нарыг нь баривчилж явчихаад хүрээ хийдийг нь эзгүй орхиод ингээд хүрээ хийд нь 1940, 50-д оны нүүрийг үзээд хүрээ хийд нь эзгүй болсон нэг хэсэг тийм түүх байгаа нөгөө талаар ерөөсөө 1937, 38 онд лам нарыг нь баривчилж авчихаад тэр дор нь сүм дуган дацанг нь галдан шатааж устгасан бас нэгэн тийм зам байгаа тэгэхээр Таширын хүрээний хувьд энэ 2-ын аль замыг нь сонгосон юм болоо тэр дор нь одоо шатааж сүм дуганыг нь байхгүй болгосон юм болов уу эзгүй хэвээрээ байгаа болов уу?

Санжаажав: Тэр ч одоо яахав дээ тэр үед чинь дээс татна л гэж байсан шүү дээ дээс гэдэг чинь одоо юу л өнөөх үүд хаалгыг нь хаачихаад л лацддаг л байж л дээ.Тэгээд хариуцсан эзэн ч байгаагүй зүгээр тэр үед лам нарын дотор нам засгаас ирсэн тийм төлөөлөгч хүн байдаг байсан байна лээ. Бас тэр улсууд бас битүү харж байсан байх,бас нэг тийм шунахай сувдаг ч гэхүү тэр дотоод юм руу халдаж байсан ч удаа бий л байхаа тийм юм дуулдаж л байсан. Тэрнээс өөр гажуу юм байхгүй юм шиг байна лээ, хүний яриагаар би нөгөө бага хүүхэд байсан болохоор дуулснаас цаашгүй л юм л даа

Д. Мөнхбат: Цогчин, маарамба , жүд одоо энэ дацангууд тухайн үедээ бол ямар ч байсан бүрэн бүтэн үлдсэн юм байна тиймээ 1937, 1938 оны үед, тэгээд одоо эд нар 1950, 1960-д оны нүүрийг үзсэн юм болов уу?

Санжаажав: Үзээгүй ээ, үлдээгүй тэр дор нь буулгаад бурхныг нь шатаагаад нэг дуганыг нь үлдээгээд тэгээд манай сүм чинь тэр байгаа газраасаа нүүсэн.

Д. Мөнхбат: Хаашаа очсон юм?

Санжаажав: Тэгээд энэ хөндийн голд, одооны байгаа газраа очсон юм. Тэгээд тэр сүмээ буулгасан банз мод юм нь тэр сумын захиргаа энэ тэрд мөн орсон тэр шавыг нь тавьж байсан ийм хэдэн газар л байсан тэгээд яахав дээ ихэнх тал нь шатаад л өнгөрсөн юм шиг байна лээ, тэгээд үлдсэн мод юмыг нь амьтан хүний бас хашаа

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хороонд орсон байх лам нарыг нь бариад дээс татсан болохоор дуудлага худалдаанд оруулж худалддаг байсан юм.Тэгээд гадуур улсад зардаг байсан байх л даа

Д. Мөнхбат: Тэгэхээр 1937, 1938 оны хэлмэгдүүлэлтийн үед лам нарыг баривчлаад том лам нарыг нь дээд ял оноодог дунд лам нарыг цэрэгт татдаг ийм ажлыг хомроглон хийж байж л дээ.Таширын хүрээнд хурал ном хүрж байсан тэр 120 гаруй лам нараас одоо хэд нь энэ цөвүүн цагийн хаялга дор өртөөд явсан байдаг юмуу хэд нь одоо ингээд хөдөө гадаа гарч хар болж үлдсэн байдаг бол энэ талаар таньд санаж байгаа юмуу ?

Санжаажав: Юу л даа тэр том лам хэлмэгддэг чинь ер нь гавжаас дээш байсан юм байна лээ . Нэг хэдэн гэцэл улс бол баригдаагүй бариа ч үгүй . Тэгээд харин тэд нарыг зохион байгуулж артель гэж гар үйлдвэрийн юм байгуулж байсан юм.

Д.Мөнхбат: Лам нарын артель ?

Санжаажав: Тийм гэлэн, гэцэл байсан улсууд чинь одоо юуны түрүүнд л баригдах байх гэж айсан байх тэднийг тийш нь оруулж байсан гэдэг юмаа

Д. Мөнхбат: Тэгэхээр энэ Таширын хүрээний тухай сүүлчийн лам нарын тухай ийм байдаг байж . Тэгэхээр энэ Булган аймгийн Могод сумын нутагт Могодын дээд доод хүрээ ч гэдэг юмуу Баавайн хүрээ ч гэдэг юмуу цагийн хурлын шинжтэй газрууд байсан байх юмаа. Тэгэхээр энэ цагийн хурлууд Таширын хүрээнээс салбарлаж байгуулагдсан байдаг юм болов уу , саяын дээр дурьдсан хүрээнүүд дээр тусдаа бие даасан байнгын ажиллагаатай хүрээнүүд байсан юм болов уу энэ талаар та юу хэлэх вэ?

Санжаажав: Үгүй юм шиг байгаа юмаа. За байз юу гэдэг байлаа даа өө тэрнийг мартчижээ.

Д. Мөнхбат: Цогчин ?

Санжаажав: Аа цогчин бишээ . Тийм газар биш яахав сайн цагийн үед хурдаг байсан хурлуудаа хурна тийм л байсандаа.

Д. Мөнхбат: Одоо энэ Могод сумын төвөөс дээш 1 км гаруй газарт байна даа хуучин рашааны орчим Дугар ламын дуган гэж байсан байх юм . Энэ одоо хир бодитой хурал байв энэ талаар таны үзэж сонсож дуулсан ямар юм байна ?

Санжаажав: Дугар лам гуай гэдэг хүн чинь энэ рашааны дэнж дээр нэг дуган амьтад хөдөлмөрчид хөдөөний хүмүүсээс бадар гуйж бариулсан юм гэнэлээ. Тэгээд дуганаа Богдод мэдэгдсэн гэж байгаа тэгээд богд түүнийг нь сайшааж хөх залаагаар шагнасан юм гэсэн.

Д. Мөнхбат: Богд Дугар ламыг ?

Санжаажав: Тийм . Тэгээд Дугар лам гуай сүүлд байж байгаад хурахаараа нэг ногоон дарь эх л хурдаг дарь эхийн цанид шөнийн түрш л ум маани бадми хүм гэж хашгирдаг хүн байсан гэдэг.

Д. Мөнхбат: Дугар лам гуай гэдэг хүн ер нь хэд орчим насалсан юм бэ 1950, 1960аад оныг үзсэн юм болов уу?

Санжаажав: Үзсэн үзсэн баригдаад явсан. Тэр бие сайтай хүн байсан бодвол тэр 80 хүрсэн юм болов уудаа, 70 их л гарсан юм байсан.Ер нь 80 гарч чадсан юм үү үгүй юмуу сайн мэдэхгүй.Тийм л хүн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Тэгэхээр Дугар ламын байгуулсан тэр дуган одоо шатаагдаж дууссан юм уу, 1950, 1960-аад оны нүүрийг бас үзсэн юм болов уу?

Санжаажав: Үзээгүй ээ үзээгүй. Тэгээд дууссан .Ганц л дуган байсан юм .Тэгээд бид нар яахав ээ нэг сайн лам болохоор нэг өдөрт очно.Хөдөөнөөс улсууд ирж тэр амьдад одоо өргөл өгч бэлэгсэлт өгдөг байсан.

Д.Мөнхбат:За одоогийн Булган аймгийн Могод сумын нутаг буюу тэр үеийн Түшээт хан аймгийн Баруун соо гүний хүрээний баруун талын нутаг дэвсгэрт бидний тооцоолсноор Буддын шашны нэг 6-7 хурал номын газар байжээ.Тэгэхээр энэ хурал номын газар ялангуяа Таширын хүрээний тухай үнэтэй мэдээлэл өгсөн танд баярлалаа.Таны өгсөн энэ мэдээлэл Монголын сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.Ингээд урт насалж удаан жаргаарай.

Санжаажав: За тэр ерөөл бат орших болтугай.

Д.Мөнхбат: За баярлалаа.